


**Эдийн засгийн өсөлт эхний улирлын байдлаар  
16.7% хүрэв**

2012 оны эхний улиралд ДНБ оны үнээр 2.3 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 30% өссөн бол 2005 оны зэрэгцүүлэх үнээр 980 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16.7% өссөн байна. ДНБ-ны өсөлтөөр тооцсон улирлын эдийн засгийн өсөлт 16.7%-д хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.7 дахин өндөр үзүүлэлт юм.




**Улсын төсвийн зарлага нэмэгдэхэд татаас ба шилжүүлгийн зардал хамгийн их нөлөөлж байна**

Улсын нэгдсэн төсвийн орлого эхний 4 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 22.3%, зарлага 31.7% тус тус өсч, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 48 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн орлого нэмэгдэхэд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад НӨАТ 42%, НДШ 56%, ААНОАТ 34%, ХАОАТ 60% тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин зарлага өсөхөд татаас ба шилжүүлэг 16%, цалин хөлсний зардал 28% өссөн нь нөлөөлөв.



**Шатахууны импорт 2 дахин нэмэгдэж, нүүрсний экспорт 50% өслөө**

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 3.4 тэрбум ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23% нэмэгджээ. Энэ өөрчлөлтөд экспорт 11%, импорт 31% өссөн нь нөлөөлсөн ба гадаад худалдаа 0.8 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Экспортын өсөлтөд эрдэс бүтээгдэхүүн тэр дундаа нүүрсний экспорт нэмэгдсэн нь нөлөөлсөн бол импортын өсөлтөд шатахуун, автомашины импортын өсөлт голлон нөлөөлөв. Зэсийн баяжмалын экспорт болон хүнд машин механизм, тоног төхөөрөмжийн импорт буурах хандлагатай байна.




**Төгрөгийн ам.доллартай харьцах ханш чангарах хандлага үргэлжилж байна**

Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш өмнөх сараас 1.5%, оны эхнээс 4.4% чангарлаа. Харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.6% суларчээ. Гадаад валютын нийт албан нөөц өнгөрсөн сараас 1.7%, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24.4% нэмэгдэв. 1 ам.долларын төгрөгөөр илэрхийлсэн үнэ ийнхүү буурч буй нь түүний нийлүүлэлт их байгаа буюу ноос ноолуурын улирал эхэлсэнтэй холбоотой.



**Инфляцын түвшин өссөөр ...**

Инфляц улам бүр өсч улсын хэмжээгээр тооцсон инфляцын түвшин 16%-д хүрлээ. Энэ өсөлтөд хүнсний барааны үнийн дундаж түвшин 26.5%, зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний үнэ 20.4% өссөн нь голлон нөлөөлжээ. Үнийн дундаж түвшин ийнхүү өсч байгаа нь нийлүүлэлтийн, ялангуяа махны нийлүүлэлтийн сөрөг хүчин зүйлээс үүдэлтэй юм.



Эх сурвалж: УСХ, МБ

САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ

**Мөнгөний нийлүүлэлт 6.4 их наяд төгрөгт хүрлээ**

M2 мөнгө буюу мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.9%, өнгөрсөн сартай харьцуулахад 4.1% нэмэгдлээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө нэг жилийн хугацаанд 12.8% нэмэгдэж, нийт мөнгөний 11.1%-ийг эзэлж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өмнөх оны мөн үетэй харьцуулсан өсөлтийн дийлэнх хувийг (84%) төгрөгийн хадгаламж, харилцахын өсөлт бүрдүүлжээ.

**Төгрөгийн хадгаламж валютынхаас хурдтай өсөв**

Хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.5%, өнгөрсөн сартай харьцуулахад 6.3% нэмэгдлээ.



Нийт хадгаламжийн 75%-ийг бүрдүүлэгч төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 26.1% өссөн бол валютын хадгаламж 16.3% өссөн байна.

Төгрөгийн хадгаламжийн 92%-ийг иргэдийн хадгаламж бүрдүүлж байна.

**Зээл өсч, чанаргүй зээлийн хэмжээ буурч байна**

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сартай харьцуулахад 2.7%, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 49% нэмэгджээ. Чанаргүй зээлийн хэмжээ буурч, нийт зээлд эзлэх хувь 5.3% болон буурсан байна.

Жилийн жигнэсэн дундаж зээлийн хүү өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад төгрөгийнх 2.0% нэмэгдэж, валютынх 0.5% буурсан үзүүлэлттэй байв.



Эх сурвалж: ҮСХ, МБ

**Сарын онцлох үйл явдал**

> Монголбанк бодлогын хүүгээ 0.5 нэгжээр нэмэгдүүлэн 13.25%, заавал байлгах нөөцийн хувийг 1 нэгжээр өсгөн 12% болгох шийдвэр гаргалаа.

> Иргэн бүрт 1.5 сая төгрөг олгох ажлын хүрээнд иргэн бүрт 536 ширхэг хувьцаа нэмж олгох, хувьцааны оронд бэлэн мөнгө (1 сая төгрөг) авах хүсэлтэй иргэдийг бүртгэж мөнгийг олгох ажлыг зохион байгуулах, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох нэг сая төгрөгийг IV, V, VI сард хуваан олгохоор шийдвэрлэв.

> ҮСХ, Дэлхийн банкны хамтарсан судалгааны дүнгээр Монгол Улсын ядуурлын түвшин 29.8% болж, өмнөх оноос 9.4 нэгжээр буурсан тухай мэдээлэл хийлээ.

> АХБ-ны "Азийн хөгжлийн төлөв 2012" тайлан хэвлэгдэн гарлаа. Уг тайланд Монгол Улсын ДНБ-ий өсөлт 2012 онд 15%, 2013 онд 17.5% хүрнэ гэж тооцоолсон байна.

**Хураангуй**

Энэ оны эхний улирлын байдлаар ДНБ-ны өсөлт 16.7%-д хүрсэн нь өнгөрсөн оны нэгдүгээр улиралтай харьцуулахад 1,7 дахин хурдтай байлаа. Эдийн засгийн өсөлт энэ онд мөн өндөр байх төлөвтэй.

Улсын төсвийн тэлэлт үргэлжилсээр байгаа ба төсвийн орлого нэмэгдэхэд татварын орлогууд, зардал нэмэгдэхэд татаас, цалингийн зардал өссөн нь голлон нөлөөлөв. Төсвийн тэлэлтийн хажуугаар гадаад худалдааны алдагдал өсч, инфляцын түвшин нэмэгдэж буй нь эдийн засагт хэт халалтын шинж тэмдгүүд байгааг харуулж байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш бага зэрэг чангарах хандлагатай байгаа нь ноос ноолуурын улирал эхэлсэн, Монголбанкны зүгээс төгрөгийн ханшийг барьж буй зэрэгтэй холбоотой.

Нийлүүлэлтийн, ялангуяа махны нийлүүлэлтийн сөрөг хүчин зүйлээс хамаарсан үнийн өсөлтийг хязгаарлах үүднээс Монголбанк бодлогын хүүгээ дахин нэмлээ. Инфляци улсын хэмжээнд 16%-д хүрч, бодлогын хүү 0,5 нэгжээр нэмэгдэн 13,25%-д хүрэв. Бодлогын хүү ийнхүү сүүлийн 2 сар дараалан нэмэгдэж буй нь зээлийн хүү өснө гэсэн айдсыг бий болгож байна. Бодлогын хүүний өөрчлөлт нь банкуудын зээлийн хүүд ерөнхийдөө 2-3 улирлын дараа нөлөөлдөг бөгөөд Монголбанкны зүгээс иргэдэд учрах инфляцын дарамтыг бууруулах үүднээс хувийн секторын зээлийг хумих сөрөг үр нөлөөтэй шийдвэрийг гаргахаас өөр аргагүй гэж тайлбарлаж байна. Гэтэл төсвийн зардал нэмэгдэж буй, бэлэн мөнгө тараах ажил үргэлжилж байгаа нь инфляцыг улам хөөрөгдөх аюултай байна. Өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хоёрдугаар улиралд багтаан нэг сая төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд нийт 334 тэрбум төгрөг олгох тооцоо гарчээ. Энэ нь зах зээлд эргэлдэж байгаа бэлэн мөнгөний 50%-тай тэнцэхүйц хэмжээний мөнгө юм.